**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 22 өдөр Дугаар А/826 Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 –ийн “л” заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төмсний үрийн чанарыг сайжруулах, нөөц бүрдүүлэх зорилгоор 100 тн төмсний үрийг хадгалах зардалд зориулан 4.250.000 /дөрвөн сая хоёр зуун тавин мянган/ төгрөгийг “Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөрөөс зарцуулсугай.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн 5.4 дахь заалтад тусгагдсан “Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрөөс 4.250.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3.Уг арга хэмжээнд хяналт тавьж сахиулыг арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Засаг даргын орлогч /Т6Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

Zax A/826 Ch
02 4150